



GRATA
INTERNATIONAL

**МОНГОЛ УЛС ДАХЬ
СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ
ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАЛТ**

www.gratanet.com





Ерөнхий ойлголт

Олон Улсын Сэргээгдэх Эрчим Хүчний Агентлаг (IRENA) болон Монгол Улсын Эрчим хүчний яам хамтран бэлтгэсэн сэргээгдэх эрчим хүчний бэлэн байдлын үнэлгээгээр Монгол Улс нар болон салхинаас жилд 15,000 15,000 тераватт цаг (ТВт/цаг) эрчим хүч гаргаж авах боломжтойг болохыг тогтоожээ. Энэ нь 18 сая тонн нүүрстэй тэнцэх эрчим хүчний нөөц юм.

Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв (NREC)-ийн тооцоолсноор Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нийт чадавх нь 2.6 тераватт буюу цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, экспортлох асар том нөөц бааз болох боломжтой байна. Ирэх арван жилд Монголын говийн нутгуудын нар болон салхины асар их сэргээгдэх эрчим хүчний ашиглах боломжтой. Энэхүү нөөцөөр дотоодын эрчим хүчний хэрэглээг бүрэн хангахаас гадна эрчим хүч дамжуулах дэд бүтцийг оновчтой шийдвэрлэж чадвал Зүүн хойд Азийн бүсийн эрчим хүчний хэрэгцээг хангах боломжтой.

Салхины Эрчим Хүч



- Монгол Улс нь томоохон салхины эрчим хүч үйлдвэрлэгч улсуудын нэг болох боломжтой.
- Ашиглах боломжтой нөөцийн хувьд нийт газар нутгийн 10% нь лг гэхэд маш сайн ангилалд багтана. Эрчим хүчний нягтрал 40-600Вт/м² бөгөөд 1100 ГВт-аас дээш суурилагдсан хүчин чадлыг хангах боломжтой.
- Салхины эрчим хүчний нөөцийн сайн-маш сайн ангилал нь 1,113,300 МВт салхины эрчим хүчийг хамардаг.

Нарны эрчим хүч

- Монгол орны ихэнх бүс нутагт жилд дунджаар 2250-3300 цаг нарны тусгалтай 270-300 орчим өдөр нартай байдаг. Нарны эрчим хүчний жилийн дундаж хэмжээ 1400 кВт.цаг/м², нарны эрчим өдөрт 4.3-4.7 кВт.цаг/м² байна.



Усан эрчим хүч




- Монгол Улсын хэмжээнд 6417.7 МВт хүртэл эрчим хүчийг дэмжиж, жилд 56.2 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүч нийлүүлэх боломжтой 3800 жижиг, том горхи, гол мөрөн байдаг.



Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний асар их нөөцтэй хэдий ч нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 93% нь нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцад түшиглэдэг ба нүүрсийг халаалтын үндсэн эх үүсвэр болгон ашиглаж ирсэн. Үүний үр дүнд, эрчим хүчний салбар нь хүлэмжийн хийн ялгаралт, агаарын бохирдлын гол эх үүсвэр болоод байна. Улсын хэмжээнд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэдэг 12 станц байгаагаас 2018 оны байдлаар нийт эрчим хүчний 7.3% буюу 413.8 сая кВт/ц-г усан болон салхин станц үйлдвэрлэжээ.



Өсөн нэмэгдэж буй цахилгаан эрчим хүчний хэрэгцээг хангах, эрчим хүчний салбарын оргил ачааллыг зохицуулах зорилгоор нийт цахилгаан эрчим хүчний хэрэглээнийхээ 20 гаруй хувийг хөрш Хятад, ОХУ-аас импортолдог. БНХАУ-аас импортолж буй эрчим хүчийг ихэвчлэн уул уурхайн үйл ажиллагаа эсвэл Оюутолгойн уурхайн ашиглалтад зарцуулдаг. УИХ-ын тогтоолоор батлагдсан Төрөөс эрчим хүчний талаар баримтлах бодлого эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хэмжээг 2030 он гэхэд 30%-д хүргэх боломжтой. Монгол Улсын Их Хурал сэргээгдэх эрчим хүчний салбар, байгаль орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжих зорилгоор 2007 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг баталсан. Тус хуульд 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ба үүнд сүлжээнд холбогдсон салхи, нарны эрчим хүчний төслүүдээс цахилгаан үйлдвэрлэх, сүлжээнд нийлүүлэх тарифын дээд хязгаарт өөрчлөлт оруулах, сэргээгдэх эрчим хүчний төслийн худалдан авах ажиллагааны журам, төсөл хэрэгжүүлэх баталгаа гэх мэт голлох өөрчлөлтүүд орсон.



Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Монгол Улсад эрчим хүчний аюулгүй байдал, найдвартай байдлыг хангах, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх, салбарын зах зээлд чиглэсэн тогтолцоог бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Сэргээгдэх эрчим хүчний төсөл сонгон шалгаруулах журам

Энэ журмаар сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл (цаашид “төсөл” гэх)-ийг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулиар тогтоосон зарчимд нийцүүлэн сонгон шалгаруулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулна. Энэ журмын үйлчлэлд эрчим хүч дамжуулах сүлжээнд холбогдон ажиллах 1 МегаВаттаас дээш суурилагдсан хүчин чадалтай нар, салхины үүсгүүр, усан цахилгаан станц, усан цэнэгт цахилгаан станц, эрчим хүчний хуримтлуур болон сэргээгдэх эрчим хүчний бусад эх үүсвэрийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх үүсгүүрийг өөрийн хөрөнгөөр барих хуулийн этгээд хамаарна.



Эрчим хүч дамжуулах сүлжээнд холбогдон ажиллах сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төслийг тогтоосон техникийн нөхцөл (техник, технологийн шийдэл), нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх үнийн саналаар тус тус өрсөлдүүлэн сонгон шалгаруулна. **Төсөл шалгаруулалт нь дараах үе шаттай байна:**

- ① төсөл шалгаруулалтын бэлтгэл үе шат;
- ② төсөл шалгаруулалтын ерөнхий нөхцлийг зарлах үе шат;
- ③ төсөл шалгаруулалтын урьдчилсан үнэлгээний үе шат;
- ④ төслийг шалгаруулах үе шат;
- ⑤ шалгарсан оролцогчтой хэлцэл хийж, гэрээ байгуулах үе шат

Төсөл шалгаруулалтад оролцогч нь урьдчилсан үнэлгээний, эсхүл эцэслэн шалгаруулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл, ирүүлсэн шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор гомдлоо шүүхэд гаргана.

Тусгай Зөвшөөрөл

Сонирхогч хуулийн этгээдийн гаргасан өргөдлийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлөөс сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих болон үйлдвэрлэх 2 төрлийн тусгай зөвшөөрөл олгоно. Хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл авахад эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:



1. сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг байршуулах зориулалтаар олгосон газрыг эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;



2. сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрт ашиглагдаж хугацаа нь дууссан зай хураагуурыг дахин боловсруулах, устгах төлөвлөгөө;

3. усны эрчмийг ашиглах барилга байгууламж барих бол газрын хөрс, ургамал, геологи, гидрогеологийн нөхцөл, газар зүйн байрлал, газрын гадаргуу, уур амьсгал, агаарын даралт, салхины горим болон ус зүйн судалгааны материал;



4. сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийн техник, тоног төхөөрөмж, барилга байгууламж нь олон улсын болон үндэсний стандартыг хангаж байгаа тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт;

5. техник, эдийн засгийн үндэслэл;

6. эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах эрчим хүчний нөөцийн судалгаа;

7. үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах эрчим хүчний төрөл, хэмжээ, чанарын үзүүлэлт;



8. үйл ажиллагаандаа ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт;
9. үйлчлэх хүрээ, эзэмшлийн зааг, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамж, хэрэглээний тэнцэл;
10. байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ;
11. байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө;
12. тухайн хуулийн этгээдийн санхүү, хөрөнгийн нөөц, эдийн засгийн чадавхи;
13. үйл ажиллагаагаа эхлэх хугацаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр;
14. мэргэжлийн боловсон хүчин, тэдгээрийн дадлага, туршлага.
15. тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь шаардлагатай гэж үзвэл өргөдөл, түүнд хавсаргасан баримтын талаар дүгнэлт гаргуулахаар хөндлөнгийн шинжээч томилж болно.

Эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор баримт бичгийн бүрдлийг шалгаж, дараах арга хэмжээ авна /баримт бичгийг нөхөн бүрдүүлэх хугацаа 30 хүртэл хоног байна. Энэ хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно/:

1. баримт бичгийн бүрдэл хангасан гэж үзвэл магадлан шалгах ажиллагааг эхлүүлэх;
2. өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх талаар зөвшөөрөл хүсэгчид мэдэгдэх;
3. өргөдлийг харьяаллын дагуу холбогдох байгууллагад шилжүүлэх.

Зөвшөөрөл хүсэгч хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг эрх бүхий этгээд ажлын 10 хоногын дотор магадлан шалгаж, уг ажиллагааг дууссанаас хойш ажлын таван өдөрт багтаан зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргана.



Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах тусгай зөвшөөрлийн хугацаа 5-25 жил, эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацаа 5 хүртэл жил, бусад тусгай зөвшөөрлийн хугацаа 10 хүртэл жил байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зохих ёсоор биелүүлсэн бөгөөд техник, технологийн хувьд цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөл, боломжтой гэж тусгай зөвшөөрөл олгогч үзвэл тусгай зөвшөөрлийн хугацааг 25 хүртэл жилээр сунгана.



Зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргана. Эрх бүхий этгээд магадлан шалгах ажиллагааг /ажлын 5 өдрийн дотор/ дууссанаас хойш ажлын хоёр өдөрт багтаан зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх шийдвэрийг гаргана.

Үнэ, тариф

Дамжуулах сүлжээнд холбогдсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифыг Эрчим хүчний зохицуулах хороо дараахь хязгаарын хүрээнд тогтооно:

- салхины эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.085 ам.доллар хүртэл;
- 5000 кВт хүртэл хүчин чадалтай усан цахилгаан станцын үйлдвэрлэж нийлүүлэх 1кВтц цахилгаан эрчим хүчийг 0.045-0.06 ам.доллар;
- нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВтц цахилгаан эрчим хүчийг 0.12 ам.доллар хүртэл.

Дамжуулах сүлжээнд холбогдсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг дэмжих тарифаар нөхөн олгоно.

Эрчим хүчний зохицуулах хороо, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөл нь хэрэглэгчийн сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээс үйлдвэрлэж, түгээх сүлжээнд нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифыг тогтоохдоо дор дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

тухайн бүс нутгийн газар зүйн байрлал, дэд бүтэц, эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал;

үнэ, тариф нь хэрэглэгчдийн худалдан авах чадавхид нийцсэн байх.

Эрчим хүчний зохицуулах хороо нь газрын гүний дулааны эрчим, биомасс болон дамжуулах сүлжээнд холбогдсоноос бусад сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэн нийлүүлэх эрчим хүчний үнийг уг үнэ, тарифын нийгэмд үзүүлэх нөлөөллийг харгалзан тогтооно, мөн эрчим хүчний системд холбогдох болон горим тохируулагч усан цахилгаан станцын үнэ, тарифыг бодит өртөг, техник, эдийн засгийн үндэслэлд тулгуурлан тогтооно.

Дамжуулах сүлжээнд холбогдсон сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх эрчим хүчний үнэ, тарифын хязгаарыг хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаатай уялдуулан тогтооно.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Хөрөнгө оруулагчид олгох хөрөнгө оруулалтын дэмжлэг нь татварын болон татварын бус дэмжлэгээс бүрдэнэ (Хөрөнгө оруулалтын тухай хууль 10 дугаар зүйл).



Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр татварын дэмжлэг үзүүлнэ:



- албан татвараас чөлөөлөх;
- албан татварын хөнгөлөлт үзүүлэх;
- албан татвар ногдох орлогоос хасагдах элэгдлийн зардлыг түргэвчилсэн аргаар тооцох;
- албан татвар ногдох орлогоос хасагдах алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох;
- ажилтны сургалтын зардлыг татвар ногдуулах орлогоос хасч тооцох.

Эрчим хүчний үйлдвэр барих тохиолдолд импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болно.

Татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг дараах хэлбэрээр үзүүлж болно:

- газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх, ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;
- чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсөн горимоор үйлчлэх;
- дэд бүтэц, үйлдвэрлэл, шинжлэх ухаан, боловсролын салбарын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоо, хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, холбогдох зөвшөөрлийг хөнгөвчилсөн горимоор олгох;
- инновацийн төслийг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, экспортод чиглэсэн инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилтэд батлан даалт гаргах;
- Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох;
- хуульд заасан бусад дэмжлэг.

Хөрөнгө оруулагчдад тогтворжуулах гэрчилгээ олгох замаар хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийн төлөх татварын хувь, хэмжээг тогтворжуулна. Хөрөнгө оруулалтын төслийг нэг хуулийн этгээд дангаар хэрэгжүүлэх бол тухайн хуулийн этгээдэд, харилцан хамаарал бүхий хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хэрэгжүүлэх бол тэдгээрийн толгой компанид тогтворжуулах гэрчилгээг олгоно. Тогтворжуулах гэрчилгээгээр доор дурдсан албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна:



- 1) аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;
- 2) гаалийн албан татвар;
- 3) нэмэгдсэн өртгийн албан татвар;
- 4) ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.



Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулинд зааснаар дараах хуулийн этгээдэд татварын хөнгөлөлт үзүүлнэ (ААНОАТТХ-ийн 22.5 дугаар зүйл):

- байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварыг;
- чөлөөт бүсэд зориулсан эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтцэд 500.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- чөлөөт бүсэд агуулах, ачиж буулгах байгууламж, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, импортыг орлох болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад 300.0 мянган америк доллар буюу түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн чөлөөт бүсээс олсон орлогод оруулсан хөрөнгө оруулалтын 50 хувьтай тэнцэх хэмжээний орлогод ногдох албан татварыг;
- албан татвар төлөгчийн 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хэрэгжүүлэх дулаан, цахилгаан үйлдвэрлэх төслийн үндсэн үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг орлого олж эхэлсний дараагийн тайлант хугацаанаас эхлэн 3 жил 90 хувь, дараагийн 3 жил 50 хувиар хөнгөлнө.

Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчийн гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татвараас хасаж тооцно. Хасаж тооцох албан татварын хэмжээг дараах шалгуураар тооцсон дүнгийн аль багаар нь тооцно:

- албан татвар төлөгчийн тухайн татварын жилийн төлбөл зохих албан татварын дүн;
- гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар ногдох орлогод Монгол Улсын татварын хуулийн дагуу ногдуулсан тохиолдолд төлбөл зохих албан татварын дүн.

Хасаж тооцох албан татварын хэмжээг баталгаажуулахдаа гадаад улсын эрх бүхий байгууллагад тайлагнасан татварын тайлан, татварын ногдол, төлөлтийг нотолсон тус байгууллагын албан бичиг, тус байгууллагын үйлдсэн татвар төлснийг нотлох баримт, тодорхойлолтыг үндэслэнэ.



Хэрэгжиж буй төслүүд [1]

Монгол Улсын Засгийн газар нь Уур амьсгалын стратегийн сан, Япон-Монголын хамтын ажиллагааны “Хамтарсан Кредит Олгох Механизм болон Азийн Хөгжлийн Банкнаас сэргээгдэх эрчим хүчний төслийг өргөжүүлэх зорилгоор санхүүжилт болон зээл авсан. Төслийн хүрээнд Баруун аймгуудын болон Алтайн Улиастайн эрчим хүчний системийн алслагдсан бүс нутагт 41.0 МВт нар, салхины сэргээгдэх эрчим хүч бий болгох боломжтой. Төсөл нь хоёр үе шаттай хэрэгжих бөгөөд эхний шат нь 2019-2022 он, хоёрдугаар шат нь 2022-2024 он хүртэл үргэлжилнэ.

Үндсэн дэд төслүүд:

- 1) **Улиастайн дэд төсөл:** Улиастайн 5МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц, 3.6МВт/цаг батерейны эрчим хүчний хуримтлалын системийн ашиглалтыг 2022 оны 10 дугаар сард эхлүүлсэн.
- 2) **Говь Алтайн дэд төсөл:** Есөнбулаг дахь 10 МВт-ын нарны цахилгаан станцын дэд төслийн гэрээг М-Си-Эс Интернэшнл ХХК гүйцэтгэсэн. Барилгын ажил эхлэх хугацааг 2023 оны 2-р улиралд тогтоосон. 2023 оны 8-р сарын 3-ны дотор байгаль орчны нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- 3) **Алтай сумын дэд төсөл:** Алтай суманд 2022 оны 7-р сараас эхлэн сүлжээнээс гадуурх 0,5 МВт-ын нарны болон батерейны эрчим хүчний хуримтлалын системийн гибрид байгууламжийг ашиглалтад оруулсан.
- 4) **Ховд аймгийн дэд төсөл:** Ховд хотын 1-р цэцэрлэгт 135 кВт-ын газрын гадаргын дулааны насос, төслийн барилгын үе шат дуусч, ашиглалтыг Броск ХХК, Нар Энержи Силикон Метал ХХК-иуд хариуцан ажиллаж байна.



Эх сурвалж

1. Сэргээгдэх Эрчим Хүчний тухай хууль (2007)
2. Эрчим Хүч Хэмнэлтийн тухай хууль (2015)
3. Хөрөнгө Оруулалтын тухай хууль (2013)
4. Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хууль (2019)
5. Чөлөөт бүсийн тухай хууль (2015)
6. Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүр барих төсөл шалгаруулалтын журам (2020)
7. Үндэсний сэргээгдэх эрчим хүчний хөтөлбөр (2005-2020)
8. Азийн Хөгжлийн Банкны Байгаль Орчны Хяналтын Тайлан: Монгол Улсад сэргээгдэх эрчим хүчний салбарыг өргөжүүлэх төсөл – 2023 он

Дэлгэрэнгүй мэдээлэл авах эсвэл асуулт байвал Грата Интернэшнл хуулийн фирмийн Партнер В.Болормаагийн bvolodya@gratanet.com болон Хуульч Б.Норовсүрэнгийн nbayarsaikhan@gratanet.com хаягаар эсвэл +976 70155031 утсаар холбоо барина уу.

Дэлхийн 20 улсад салбартай олон улсын хуулийн фирм Грата Интернэшнлийн Монгол дахь оффис болох Өмгөөллийн “Грата Интернэшнл Монголиа” ХХН энэхүү хууль зүйн мэдээллийг бэлтгэн хүргэв. Энэхүү хуулийн зүйн мэдээлэл нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд тодорхой асуудалд нарийвчлан дүн шинжилгээ хийгээгүй болно. Иймд уншигч нь ямар нэгэн үйлдэл хийх/эс хийхээс өмнө өөрсдийн нөхцөл байдалд тохирсон мэргэжлийн зөвлөгөө авах хэрэгтэй. Энэхүү хууль зүйн мэдээллийг ашигласны улмаас үүссэн аливаа үр дагавар, хохирлыг бид хариуцахгүй.



About GRATA International

GRATA International is a dynamically developing international law firm which provides services for projects in the countries of the former Soviet Union and Eastern Europe: full coverage of the entire region with network of offices, highly qualified team of professionals suited for cross-border projects. Firm's reputation and expertise are confirmed by testimonials from transnational clients and leading international ratings.

A wide network of office operating under one system and platform delivers great convenience for our clients. Any office can act as a "one-stop-shop" for its clients and provide them with access to services in other cities and countries. If necessary, inter-office teams with relevant experience are assembled to provide solutions to complex tasks. Service quality is assured by a clear system of organisation of this process.

GRATA International is present in the following jurisdictions: Armenia (Yerevan), Azerbaijan (Baku), Belarus (Minsk), Cyprus (Limassol), Georgia (Tbilisi), Kazakhstan (Aktau, Almaty, Atyrau, Astana, and other cities), Kyrgyz Republic (Bishkek), Moldova (Chisinau), Mongolia (Ulaanbaatar), Russia (Moscow, St. Petersburg, Rostov-on-Don, Samara), Tajikistan (Dushanbe), Turkmenistan (Ashgabat), Turkey (Istanbul), UAE (Dubai), Ukraine (Kyiv) and Uzbekistan (Tashkent).

In addition to its offices, GRATA International has representatives in the UK (London), Germany (Frankfurt), the USA (New York), China (Beijing), Switzerland (Zurich), Malaysia (Kuala Lumpur).

GRATA International is regularly acclaimed by leading international rankings: Chambers Global, Chambers Asia-Pacific, Legal 500, IFLR1000, WWL, Asialaw Profiles, and is featured in Deals of the Year Awards by China Business Law Journal.


Key Industry Sectors:

- Banking & Finance
- Construction & Infrastructure
- Industry & Trade
- Mining
- Oil & Gas
- Pharmaceuticals & Healthcare
- Technology, Media & Telecommunications
- Transport



> 22

countries of presence



> 31

years of experience




> 250

professionals




> 15

practice areas



7700+

clients



15 000+

projects



Global Presence



Integrated Offices

Azerbaijan

Baku

Kyrgyzstan

Bishkek

Tajikistan

Dushanbe

Belarus

Minsk

Moldova

Chisinau

Ukraine

Kyiv

Georgia

Tbilisi

Mongolia

Ulaanbaatar

Uzbekistan

Tashkent

Kazakhstan

Astana
Almaty
Atyrau
Aktau, etc.

Russia

Moscow
Rostov-on-Don
St. Petersburg

Armenia

Yerevan



Associate Offices

Cyprus

Limassol

Russia

Samara

Turkmenistan

Ashgabat

Turkey

Istanbul

UAE

Dubai



Representatives

China

Beijing

Germany

Frankfurt

Malaysia

Kuala Lumpur

Switzerland

Zurich

UK

London

USA

New York